sendmn
мөнгөн гуйвуулга

# 2023 оны жилийн тайлан




## Сэнд Эм Эн ББСБ ХХК

**Мөнгөн гуйвуулгыг гэрлийн хурдаар**

# АГУУЛГА


## Компанийн тухай

05 Эрхэм зорилго, Алсын хараа, үнэт зүйлс

06 Комплайнс, эрсдлийн удирдлага

07 Хүний нөөц

## Бизнесийн үйл ажиллагаа

10 Үйл ажиллагааны хураангуй

11 Компанийн онцлох үйл явдлууд

12 Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа

# КОМПАНИЙН ТУХАЙ

**Шилдэг валют арилжааны байгууллага**
**2023**

**Монгол улсын шилдэг мөнгөн гуйвуулгын компани**
**2022**

**Шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээтэй байгууллага**
**2021**

# MISSION STATEMENT



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхий даяар тархан суурьшсан Монгол иргэдийн мөнгөн гуйвуулгын бүх асуудалд хамгийн хямд бөгөөд хамгийн хурдан шийдлийг санал болгоно..

## АЛСЫН ХАРАА

Монгол улсын үсрэнгүй хөгжилд хувь нэмрээ оруулсан олон улсын түвшинд өрсөлдөхүйц мөнгөн гуйвуулгын компани байна.

## ҮНЭТ ЗҮЙЛС

Үр дүн, Хариуцлага, Багийн ажиллагаа, Ил тод байдлыг бид үнэт зүйлээ болгон эрхэмлэнэ.

# КОМПЛАЙНС, ЭРСДЛИЙН УДИРЛАГА

## Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх:

Бид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол улсын хууль дүрэм журмыг дагаж мөрддөг бөгөөд өөрсдийн санхүүгийн болоод бизнесийн үйл ажиллагааг тус хууль, дүрэм журамд нийцүүлэн, тууштай баримталж ажиллаж байна.
Монпеп дата ХХК-ийн “sanctions compliance” программаар олон улсын хориг, улс төрд нөлөө бүхий этгээд, тэдгээрийн хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн мэдээллийг шүүж, байнгийн хяналт хийж байна.

## Мэдээллийн аюулгүй байдал, хадгалалт, хамгаалалт:

"Сэнд Эм Эн ББСБ" ХХК 2023 оноос олон улсын мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC27001:2013 стандартыг өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Ингэснээр манай компани бизнесийн харилцаа тогтоосон бүх л оролцогч талуудын мэдээллийг олон улсын стандартын дагуу найдвартай хамгаалан ажиллаж байна.

## Зохицуулагч байгууллагууд

FINANCIAL REGULATORY COMMISSION OF MONGOLIA

MONGOLBANK
CENTRAL BANK OF MONGOLIA

# ХҮНИЙ НӨӨЦ

Нийт ажилтнуудын тоо **46**




Дундаж нас **29**

**Хангамж:** Хоол унааны хангамжийг бэлэн мөнгөөр, бензин талоноор, таксины эрхээс сонгоод авах боломжийг нээв.

**Эрүүл мэндийн үзлэг:** Жилд 1 удаа эрүүл мэндийн бүтэн үзлэгт орох эрхтэй.

**Уян хатан ажлын цаг:** 08:00-09:30 хооронд өөрийн хүссэн цагтаа ирэх боломжтой бөгөөд цагаа заавал хатуу сонгох шаардлагагүй болсон.

**Mentorship, сургалт хөгжил:** Бүх ажилтнуудын сургалт хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж ажлын байранд болон хувь хүний хөгжилд шаардлагатай дотоод, гадаад сургалтанд хамруулсан ба мөн дотооддоо 1 ментор сонгож хувийн хөгжил, мэдлэгээ сайжруулах хөтөлбөр зохион байгуулсан.

**Чөлөөт цаг:** Ажилтнуудын чөлөөт цагаа өнгөрөөх амрах, тоглох хэсгийг бүрдүүлсэн бөгөөд дартс, ширээний хөлбөг, Playstation зэргийг нэмэгдүүллээ.

# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 01 МӨНГӨН ГУЙВУУЛГА

Үйл ажиллагааны лицензээ 2017 онд авсан. 170 улс руу гар утаснаасаа гуйвуулга илгээх, хүлээн авах, 15 улс руу бизнесийн гуйвуулга илгээх боломжтой. Шимтгэлийн хувьд уламжлалт арилжааны банктай харьцуулахад 3-4 дахин бага.

## 02 ВАЛЮТ АРИЛЖАА

Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудал болон 8 шарга валют арилжааны салбартай. SendMN апп-аар дамжуулан валютаа урьдчилан захиалж, нисэхээсээ өмнө салбараас очер дараалалгүй авах үйлчилгээг нэвтрүүлсэн.

## 03 ЗЭЭЛ

Хэрэглээний, автомашин, орон сууц, хашаа байшин барьцаалсан, цалингийн, ЖДБ-ийн зээлүүдийг гаргадаг.

## 04 ИТГЭЛЦЭЛ

Доллар болон төгрөгийн итгэлцлийг хөрөнгө оруулагч, харилцагч нартаа өндөр өгөөжтэй санхүүгийн бүтээгдэхүүнийг санал болгож байна.

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГҮЙ

### Нийт гуйвуулга
*Тэрбум төгрөг*




### Татан төвлөрүүлсэн хөрөнгө
*Тэрбум төгрөг*




### Зээлийн багц
*Тэрбум төгрөг*




### Төлсөн татвар
*Сая төгрөг*




### Валют арилжаа
*Тэрбум төгрөг*




# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД - 2023

- Мэдээллийн технологийн аюулгүй байдлын тогтолцоо ISO/IEC 27001:2013 стандартыг бизнесийн үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлсэн

- Гадаадад зорчих гэж буй иргэд SendMN апп-с валютаа урьдчилж захиалах боломжтой болсон. Энэхүү үйлчилгээгээрээ бид ББСБ холбооны "Алтан Од" хүндэтгэлийн арга хэмжээнээс "2023 оны шилдэг валют арилжааны байгууллага" хүндэт цомыг гардан авсан.

- ICT Expo 2023, Финтек саммит – Silkroad 2.0, Сингапур улсын финтек саммитэд амжилттай оролцсон

- АНУ, Канад, Австрали улсын шууд гуйвуулгыг зах зээл дээрх хамгийн таатай ханш, хамгийн хямд шимтгэлээр санал болгож эхэлсэн.

- Япон улсын QS Remit компанитай хамтын ажиллагаа эхлүүлж руу Япон улс руу шууд мөнгөн гуйвуулга хийх боломжийг харилцагч нартаа нээсэн.

- Их британийн нэгдсэн вант улсын IME London компанитай хамтын ажиллагаа эхлүүлж тус улс руу шууд мөнгөн гуйвуулга хийх боломжийг харилцагч нартаа нээсэн.

- Турк улсын хамгийн том Мөнгөн гуйвуулгын компани болох UPT-тэй хамтын ажиллагаа эхлүүлж Турк улс руу шууд мөнгөн гуйвуулга хийх боломжийг харилцагч нартаа нээсэн.

# МӨНГӨН ГУЙВУУЛГА

## Бүтээгдэхүүн үйлчилгээ




**Гарах гуйвуулга**

**SendMN** апп-р дамжуулан дэлхийн 170 гаруй орон руу шижлүүлэх боломжтой

**Орох гуйвуулга**

24/7 тасалдалгүйгээр харилцагчийн мөнгийг хүлээлгэн өгдөг.

**Байгууллага**

Байгууллагын гүйлгээ болон байгууллага руу гүйлгээ хийх боломжтой

**Төлбөрийн хэлбэр**

Банкны данс руу, цахим түрийвч рүү гуйвуулгаа хүлээн авах эсвэл салбарт биеэр очин бэлнээр авах боломжтой

**Ханш**

Төв банкны ханштай уялдуулан өөрсдийн ханшийг тогтоодог. Энэ нь ханшийн таатай нөхцлийг харилцагчдад олгодог

**Харилцагчийн туслах**

Өдөрт 15 цаг, жилийн 365 өдөр харилцагчдад тусламж үзүүлэхэд бэлэн байдаг.

# ҮЙЛ АЖИЛЛАГАА – НИЙТ ГУЙВУУЛГА

Бид 2023 онд **157.1 сая** ам.долларын буюу **541.8** тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгыг хийсэн бөгөөд үүнээс 330 тэрбум төгрөгийг гадаад улсаас хүлээн авсан. Энэхүү үзүүлэлтийг 2022 онтой харьцуулахад **81%-р** өссөн үзүүлэлт юм.

